

Article

Applying Frame Analysis to the Classification of the Speech Act of Gratitude

Altantuya Luvsandorj*

Department of English, School of Humanities and Social Sciences, International University of Ulaanbaatar, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: altantuya.l@ulaanbaatar.edu.mn



<https://orcid.org/0009-0007-0730-6773>

Received: 09 March 2026. Accepted: 25 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

A speech act is the smallest unit of discourse, or the verbal interaction between a speaker and a listener, aimed at achieving a specific perlocutionary goal of the speaker by creating discourse meaning in the process of communication. An utterance is studied in the theory of speech acts, which is the most important component of pragmatic linguistics, and is classified into informing, giving a command, making a commitment, expressing an emotion, and declaring, taking into account the illocutionary goal, the psychological state of the speaker, the direction of correspondence between the semantic specificity of the proposition of a speech act and reality, and the relationship between the utterance and social institutions. An act of gratitude is a form of expressive act that aims to express the speaker's reaction to a specific situation or psychological state. Recently, the method of frame analysis has been widely used in linguistic research. A frame is a comprehensive information or knowledge system about a specific event in a person's life. The frame consists of slots with their own characteristics, depending on the psychological characteristics of the interlocutors and the conditions of communication, and their number is equal to the number of elements that make up the event. The frame method allows you to determine the characteristics of performing various speech acts depending on the prerequisites for the implementation of the speech act, thereby facilitating the study of language units from a paradigmatic and syntagmatic perspective. The concept of "gratitude", which is the main object of our research, is a socio-cultural phenomenon that reflects the mentality and unique culture of a given nation, and in this article we aim to consider the speech act of gratitude from a frame semantics point of view. Specifically, based on the cognitive model proposed by the Russian linguist A.G.Berdnikova, we conducted our research using methods such as observation, analysis and synthesis, interpretation, and comparison in order to identify the frame-and-slot structure of the speech act of gratitude in Russian and Mongolian. By studying approximately 1,000 utterances conveying meaning of gratitude, selected from classical literary works written in the two languages, we have found that although there are a number of similarities in the ways gratitude is expressed, there are also differences connected to the social and cultural characteristics of the respective countries.

Keywords: Pragmatics, cognition, propositional content of an utterance, politeness system, slot



©2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Талархах үйлийг ангилахад фреймийн анализын аргыг ашиглах нь

Лувсандоржийн Алтантуяа

Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Хүмүүнлэг, нийгмийн ухааны сургууль, Англи хэлний тэнхим,
Улаанбаатар хот, Монгол Улс

Хураангуй

Хэлэх үйл бол дискурсийн хамгийн бага нэгж буюу харилцааны үйл явцад дискурсийн утга бүтээх замаар яригчийн тодорхой перлокутив зорилгыг хангахад чиглэгдсэн яригч, сонсогч хоёрын хоорондын хэлэхүйн харилцан үйлдэл юм. Хэлэх үйлийг прагматик хэл шинжлэлийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох хэлэх үйлийн онолд судалдаг бөгөөд иллокутив зорилго, яригчийн сэтгэл зүйн байдал, хэлэх үйлийн пропозицын утгын онцлог, бодит байдал хоёрын нийцлийн чиглэл, хэлэх үйл, нийгмийн институт хоёрын хоорондын холбоо зэргийг нь харгалзан мэдээлэх, захирах хүсэх, үүрэг амлалт авах, сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлэх, зарлан тунхаглах гэж ангилдаг. Талархах үйл нь яригчийн тодорхой нөхцөл байдалд үзүүлэх хариу үйлдэл буюу сэтгэл зүйн байдлыг илэрхийлэх зорилготой экспрессив үйлийн нэг хэлбэр юм. Сүүлийн үед хэл шинжлэлийн судалгааны ажилд фреймийн анализын арга өргөн хэрэглэгдэж байна. Хүний амьдралд тохиолдсон тодорхой үйл явдлын талаарх цогц мэдээлэл буюу мэдлэгийн тогтолцоог фрейм гэдэг. Фрейм нь харилцагчдын сэтгэл зүйн онцлог болон харилцааны нөхцөлөөс хамаарсан тус тусын онцлог шинж бүхий слотуудаас тогтох бөгөөд тэдгээрийн тоо нь тухайн үйл явдлыг бүрдүүлж буй элементүүдийн тоотой адил байна. Фреймийн арга нь хэлэх үйлийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөлөөс хамааран янз бүрийн хэлэх үйлийг үйлдэх онцлогийг тогтоох боломжийг олгодог бөгөөд ингэснээрээ хэлний нэгжүүдийг парадигматик болон синтагматик үүднээс судлахад тус дөхөм болдог. Бидний судалгааны ажлын гол объект болох “талархал” хэмээх концепт нь тухайн улс үндэстний сэтгэлгээ (менталитет), өвөрмөц соёлыг тусгасан нийгэм-соёлын үзэгдэл бөгөөд бид энэхүү өгүүлэлдээ талархах үйлийг фреймийн онолын байр сууриас авч үзсэн юм. Тухайлбал, Оросын хэл шинжлэлч А.Г.Бердниковагийн санал болгосон талархах үйлийн когнитив загварт тулгуурлан орос, монгол хэлний талархах үйлийн фрейм, слотын бүтцийг илрүүлэн гаргах зорилгоор ажиглалт, анализ ба синтез, тайлбарлах, зэрэгцүүлэх аргуудыг ашиглан уг судалгааныхаа ажлыг хийлээ. Ийнхүү хоёр хэлний талархах үйлийг дээрх хэлээр бичигдсэн сонгодог уран зохиолоос түүвэрлэн авсан талархах утга бүхий 1000 орчим жишээн дээр зэрэгцүүлэн судалж үзэхэд адил төстэй зүйл нэлээд байгаа боловч тухайн орнуудын нийгэм, соёлын онцлогтой холбоотой ялгаатай зүйл ч бас байгаа нь тогтоогдсон болно.

Түлхүүр үгс: Прагматик хэл шинжлэл, танихуй, өгүүлэмжийн пропозицын агуулга, эелдгийн ай, слот, сценар

Оршил

Өнөөдөр хэлэх үйл хэмээх нэгж маргаан дагуулсаар байгаа бөгөөд дискурсийн судалгааны арга зүй энэ ойлголтыг эргэн харахыг шаардаж байна. Хэлэх үйлийн сонгодог онолд түүнийг хэлэх үйлдлийн (харилцан үйлдэл биш) (Остин, 1986) хамгийн бага нэгж гэж үздэг бөгөөд зөвхөн яригч болон түүний зорилгын үүднээс авч үздэг. Харин шинэ когнитив-коммуникатив парадигмд энэ ойлголт шинэ утга агуулгатай болж байна. Дискурсийн утгыг тайлахад сонсогч чухал үүрэгтэйгээс гадна хам сэдэв, бодит нөхцөл, харилцагч талуудын суурь мэдлэг (пресуппозиц)-ийг ч харгалзан үздэг. Аливаа хэлэх үйлийн когнитив загварыг тодруулан гаргах, тодорхой үйлийг заадаг өгүүлэмжийг судлахад талархах үйлийн когнитив судалгаа чухал ач холбогдолтой юм. Ой ухаандаа хадгалагдан үлдсэн тодорхой нөхцөл байдлын когнитив загвар буюу сценар дээр тулгуурлан яригч талархах үйлийг бүтээж сонсогч түүнийг нь зөв ойлгож хүлээн авах боломж бүрддэг.

Хэлэх үйлийн асуудал орос хэл шинжлэлийн тэргүүлэх чиглэлүүдийн нэг хэвээр байгаа бөгөөд энэ талаар хийгдсэн судалгааны ажил цөөнгүй. Тухайлбал, Н.В.Возияновa, В.И.Карасик, А.А.Романов, Н.И.Формановская нар хэлэх үйлийн ангилал, А.В.Бондарко, Е.М.Вольф, А.А.Уфимцева, Е.В.Падучева нар перформатив үйл үгийн хэлбэр (аспект), Г.Г.Почепцов, И.М.Кобозева, Е.В.Милосердова, В.В.Дементьев нар шууд бус хэлэх үйл, А.С.Бочкова, И.А.Кивенко, В.В.Айвазова нар талархах үйл, И.С.Шевченко хэлэх үйлийн когнитив-прагматик шинж гэх мэт чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж иржээ.

Монгол хэл шинжлэлд энэ асуудлын талаар хийгдсэн даацтай судалгаа үгүй ч зэрэгцүүлсэн хэл шинжлэлийн хүрээнд доктор, профессор Б.Чулуундорж, доктор, профессор Э.Равдан нар өөрсдийн бүтээлдээ тодорхой хэмжээгээр тусгасан байдаг. Мөн Д.Нармандах хэл шинжлэлийн ухааны докторын (Ph.D.) зэрэг горилсон “Англи, монгол хэлний талархлын үйлийг илэрхийлэх байдал” ганц сэдэвт зохиолдоо талархах үйлийг илэрхийлэх арга, хэлбэрийг судалсан байна. Үүнээс гадна хэлэх үйлийг эелдгийн айтай холбож үзсэн ажил цөөнгүй байна. Эдгээр бүтээлүүд нь бидний ажилд онол, арга зүйн талын ихээхэн нөлөө үзүүлснийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Бид фреймийн анализын аргыг ашиглан орос, монгол хэлний талархах үйлийг ангилах зорилгоор дээрх хэлээр бичигдсэн сонгодог уран зохиолоос түүвэрлэн авсан талархах утга бүхий 1000 орчим жишээн дээр ажиглалт, анализ ба синтез, тайлбарлах, зэрэгцүүлэх аргуудыг ашиглан уг судалгааныхаа ажлыг хийлээ. Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг шийдвэрлэсэн болно. Үүнд:

- талархах үйлийн фреймийн бүтцийг нээн илрүүлэх;

- орос, монгол хэлний талархах үйлийн фреймийн бүтцийн ижил төстэй болоод ялгаатай талыг тодруулах.

Хэлэх үйлийн судалгаа монголын хэл шинжлэлд харьцангуй шинэ тутам байгаагийн дээр түүний нэгэн төрөл болох талархах үйлийг орос, монгол хэлэнд зэрэгцүүлэн судалсан судалгааны ажил хийгдээгүй байгаа учир бид энэхүү сэдвийг сонгон авлаа.

Судалгааны хэсэг

Үгсийн сан, хэл зүй, прагматик нэгжийн фреймийн судалгааг судлаачид орчин үеийн судалгааны, ялангуяа соёл хоорондын харилцаа болоод бүхэлдээ харилцааны онолын хүрээнд хамгийн чухал арга гэж үздэг. Фрейм бол хүний ой санамжид байгаа сэтгэл зүйн буюу танихуйн загвар юм. Өөрөөр хэлбэл хүн ой ухаандаа байгаа бодит амьдралаас олж авсан мэдээллүүд болох ой санамждаа байгаа фреймүүдтэй зэрэгцүүлж үзэх замаар бодит байдлыг хүлээн авдаг гэсэн үг юм. Өнөөдөр гадаадын эрдэмтэн судлаачид хэл шинжлэлийн асуудлыг фреймийн анализын аргын тусламжтайгаар судлах явдал түгээмэл ажиглагдаж байна. Фреймийг хүний мэдлэг болон түүний хуримтлуулсан туршлагыг нэгтгэсэн универсал категори гэж тодорхойлдог. Фрейм нь хүний ой ухаанд хадгалагдаж байгаа ойлголтууд болон тэдгээрийг боловсруулах үйл явцыг эмхэлж цэгцэлж өгдөг. Улмаар ирээдүйд болох үйл явдлыг өмнө нь болж байсан бүтцийн хувьд төстэй үйл явдал дээр тулгуурлан урьдчилан таамаглах боломжийг олгодог. Фрейм бол мэдлэг бүтээх гол хэрэгсэл юм. Тухайлбал, Р.М.Желтухина “Концептыг сэтгэхүйн нэгж гэж үзвэл, фрейм нь энэхүү мэдлэгийг бүтээх хэлбэр, сэтгэхүйн үйл явцыг зохион байгуулах арга болно” (Желтухина, 2003) гэж тодорхойлжээ. Когнитив шинжлэх ухаан, ялангуяа когнитив хэл шинжлэл, когнитив сэтгэл судлал, хүн судлалын хүрээнд фреймийн онол нь хэлэх үйлийн судалгааны эхлэх цэг болоод зогсохгүй түүнийг амьдрал дээр хэрэгжүүлэх нэлээд сонирхолтой онол болно (Рудаков, 2002). Хэлэх үйлийн судалгаа нь хэлэх үйлийг амаар илэрхийлэх үйл явц, аргууд болон аливаа хэлэн дэх хэлэх үйлийн тодорхой хэв шинжийг прагматик талаас зохион байгуулах аргыг тайлбарлахад нэлээд ач холбогдол бүхий судалгааны чиглэл юм. Аливаа хэлэх үйлийн когнитив загварыг гаргах, тодорхой үйлийг илэрхийлсэн өгүүлэмжийг судлахад талархах үйлийн когнитив судалгаа чухал ач холбогдолтой юм.

Оросын хэл шинжлэлч В.В.Айвазова талархах үйлийг сценар гэсэн концептын үүднээс судалж болно гэж үзсэн байдаг. Тэрээр сценарыг хэвшмэл болсон үйл явдлуудын цаг хугацааны хувьд эрэмбэлэгдсэн дэс дарааллыг дүрсэлсэн цаг хугацааны болон учир шалтгааны холбоосоор хоорондоо холбоотой ойлголтуудын цогц (Айвазова, 2011) гэж тодорхойлжээ. Ямар ч харилцааны нөхцөл тэр дундаа талархал илэрхийлэх нөхцөлийн үндэс нь тухайн нөхцөлийн

ерөнхий дүр төрх болох сценар юм гэж үздэг. Талархах үйлийн сценарт дараах хоорондоо харилцан уялдаатай мэдээллүүд багтана. Үүнд:

- аливаа сайн үйлийг ямар нэгэн хэмжээгээр шагнаж урамшуулах ёстой гэсэн суурь ойлголттой байх;
- талархал илэрхийлж буй субъектийн үндсэн санаа зорилгын тухай төсөөлөлтэй байх;
- тухайн объект субъектэд ямар нэгэн байдлаар тус хүргэсэн гэдгийг ухамсарласан байх;
- талархал илэрхийлэх үеийн харилцааны нөхцөлүүдийн тухай ойлголттой байх;
- талархсан сэтгэлээ илэрхийлэх байж болох бүхий л аргуудыг мэддэг байх (шууд болон дам);
- талархал илэрхийлэхгүй байх нь эелдэг ёсонд нийцэхгүй болохыг мэддэг байх.

Он цагийн дарааллын хувьд хэлэх үйлийг нөхцөл байдалтай нэгэн зэрэг, нөхцөл байдлын өмнө нь болон дараа нь болсон гэж гурав ангилж болох бөгөөд үүнийг уламжлалт хэл шинжлэлд одоо, өнгөрсөн, ирээдүй цагаар томъёолж ирсэн билээ. Талархах үйлийн пропозицын¹ агуулга бусад экспрессив хэлэх үйлийн нэгэн адил өвөрмөц шинжтэй бөгөөд гол төлөв өнгөрсөн цаг руу чиглэсэн байдгийг бидний судалгаа харуулж байна.

Одоо цагт холбогдох талархах үйл. Энд “харьцангуй одоо цаг”-ийн тухай яригдаж байгаа бөгөөд яригч сонсогчийн “саяхан” хийсэн сайн үйлд тэр дор нь талархал илэрхийлж буй хэрэг юм. Жишээлбэл:

“ - А вот у нас, помещиков, все плохо идет с работниками, - сказал Левин, подавая ему стакан с чаем. - Благодарим, - отвечал старик, взял стакан, но отказался от сахара, указав на оставшийся обгрызенный им комочек (Толстой, Анна Каренина, 2008). ”

“Туслагч сархад хундагалан өвгөнд барьж - Та тавтай сууж зооглогтун. Би нэрэлхсэн хүнд гомдохчихдог юм шүү гэж найр тавин инээмсэглэж архины хооронд бэрсүүжиж улайсан нүүрээ хааяа илж малилзана. - Гялайлаа, туслагчтан! Сүх хундагатай архинд уруул хүргээд тавилаа (Бямба, 1971). ”

Одоо цагтай дүйцэх талархах үйл анхаарал халамж тавих, санал болгох, зөвлөгөө өгөх зэрэг үйлдлийн үед ихэвчлэн тохиолдож байгаа бөгөөд дахин давтагдахгүй, нэг л удаа болдог онцлогтой. Энэ төрлийн талархах үйл орос, монгол хэлэнд адилхан илэрч байгаа бөгөөд бидний түүвэрлэсэн жишээний 30 орчим хувийг эзэлж байна.

Өнгөрсөн цаг руу чиглэсэн талархах үйл. Энэ нь хамгийн түгээмэл буюу нийт жишээний 50 орчим хувийг эзэлж байгаа сонсогчийн өмнө нь хийсэн сайн үйлийн хариуд яригчийн үзүүлж буй хариу үйлдэл юм. Иймэрхүү талархах үйлийн пропозицын агуулга нь бодит байдалд

¹ Өгүүлэмжийн иллокутив зорилго агуулаагүй утга

нийцэхээс гадна бусад цагийг бодвол пресуппозицын² агуулга нь нэлээд баялаг, өргөн хүрээтэй байдгаараа онцлог бөгөөд цаг хугацааны хувьд нэлээд ойр; ойр; харьцангуй ойр; хол; хэт хол болсон гэж ангилж болохоор байна.

Нэлээд ойр: “Харьцангуй одоо цаг”-тай дүйх, “саяхан” болсон нөхцөл байдал. Жишээлбэл:

“- Спасибо, милый друг, что приехала (Толстой, 1984).”

“- Төрбат аа, май хүү минь сайхан сүүтэй цай ууж үз. Ядраа биз дээ? Ойрд ер нь алба ихтэй байгаа даа янз нь. Эмээ нь аяга шөл цахилгаан зуухан дээр тавьчихлаа. Шөл уугаад эртхэн унтаж амар. - Баярлалаа эгчээ.

Ойр: “Өнөөдөр” буюу тэр өдөртөө болж өнгөрсөн нэг удаагийн үйлдэл. Жишээлбэл:

“Он минутой колебался, потом решительно спросил: - Отчего это у нее? – Не знаю. – Кто тебе сказал, что она в больнице? – Ашкен Степановна. Лена в тяжелом состоянии. – Спасибо, что позвонила, я съезжу в больницу (Рыбаков, 1980).”

“- Зарим санаа давхардсанаас бусад бүх асуултанд хариуллаа. Бидэнд сайхан лекц уншиж өгсөн нөхөр Билгүүнд баяр хүргэе гэхэд сонсогчид хөөрөн алга ташиж өөр хоорондоо ярилцан шуугисаар буужигналдан бослоо (Бямба, Үнэний хорвоо, 1983).”

Харьцангуй ойр: “Өчигдөр” буюу нөхцөл байдал нь талархах үйлээс нэг өдрийн өмнө болсон үйл хэрэг. Хугацаа нь уртсаж байгаатай холбоотойгоор нэг удаагийн болоод давтагдсан үйлдэл байж болно. Жишээлбэл:

“Криворучко еще работал заместителем директора по хозяйственной части. Прикладывая печать, он вполголоса сказал: - Стандартные справки на декабрь отправлены в картонное бюро. - Спасибо, - ответил Саша (Рыбаков, 1980).”

- За Дамбий гуай бид танайд сайхан амарлаа. Одоо явах уу даа. Завтай байсан бол жаал хань болж баймаар санж. Очих газар хол гээд Дэмбэрэл, Дандигай хоёр алсынхаа замд гарав. -Сайн яваарай! Та нар ирсэнд өвгөн би их баярлалаа. Дотроо бухимдсан зовлонгоо тайлж нулимсаа тайллаа гээд хоцорч билээ.

Хол: Талархах үйлээс хэдэн долоо хоног, сар, жилийн өмнө нэг юм уу олон удаа болсон нөхцөл байдал. Жишээлбэл:

“- Разумеется, я воображаю, что вам, городской хозяйке, здесь дико, и, если что нужно, я весь к вашим услугам, - сказал Левин. - О нет! - сказала Долли. - Первое время было неудобно, а теперь все прекрасно устроилось благодаря моей старой няне (Толстой Л. , Анна Каренина, 2008).”

² Суурь мэдлэг

- Таны явсан хэрэг бүтэмжтэй болсонд харц ард би туйлын баяртай байна. - Ядарч зүдэрсэн үед тус хүргэсэн таны ачийг би мартаггүй гэж Ханд ванг хэлэхэд Бөмбөөгийн нүүрэнд баясал гэрэлтэв.

Хэт хол: Талархах үйлээс нэлээд хугацааны өмнө дахин давтан болсон нөхцөл байдал. Заримдаа хүний бүхий л амьдралыг хамрах нь ч бий. Жишээлбэл:

“ - Я думала, что вы позволите мне сказать вам это, - сказала она. - Мы так сблизились с вами... и с вашим семейством, и я думала, что вы почтете неуместным мое участие, но я ошиблась. Я не знаю почему, - продолжала она, оправившись, - вы прежде были другой и ... - Есть тысячи причин почему. - Благодарю вас, княжна, - сказал он тихо (Толстой, 1984). ”

- Та өчүүхэн намайг итгэж энэ хариуцлагатай ажил хийлгэж байгаад би их баярлаж байдаг юм.

Өнгөрсөн цагтай холбоотой талархах үйлийн пропозицын агуулга хэлэх үеэс холдох тусам өөрчлөгдөж нэг удаа болсон үйлээс эхлэн олон удаа болсон үйлийг зааж байгаа нь харагдаж байна.

Ирээдүй цаг руу чиглэсэн талархах үйл. Юу болохыг харилцагч талууд шууд ажиглах боломжгүй байдгаараа дээрх хоёр хэлбэрээсээ ялгагддаг бөгөөд пропозицын агуулга нь бодит байдалд нийцэхгүй буюу таамаглал болно. Иймэрхүү жишээ хамгийн бага буюу нийт жишээний 20%-д тааралдаж байна.

“ - Кабы проводил кто до поворота, - сказал Василий Андреич. - Что же, это можно, - сказал старший сын. - Петруха запряжет, да и проводит до поворота. - Так запрягай, брат. А уж я поблагодарю (Толстой, Хозяин и работник, 2007). ”

- Дотоодыг хамгаалах яамныхан чамайг өдийд хороогдсон хүний л тоонд оруулаа л даа. Тэгэхээр би хот орж байгаад хөөцөлдөж чамайг цагаатгасан бичиг олж өгөхийг бодъё. - Ээ их баярлалаа. Тэгэхээр би энд амьд байгаа болохоор яахав?

Фрейм, слотын бүтэц нь бодит ертөнцийн шинжлэх ухааны үндэстэй ойлголтыг илэрхийлдэггүй, харин судлаачдын хэлж байгааг бодит ертөнцийн тухай өдөр тутмын энгийн, гэнэн төсөөлөл юм. Слот гэдэг нь хэлбэржсэн нөхцөлийн элементүүдийн цогц юм (Төмөрхуяг, 2011). Слотын шинж чанарын тухай ярих үед “концепт” гэдэг нэр томъёог хэрэглэдэг. Хүний бүхий л үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй орчлон ертөнцийг таньж мэдэхэд чиглэгдсэн үйл явцын үр дүнг тусгасан хүний сэтгэн бодох үйл ажиллагаанд ашиглагддаг төгс хийсвэр нэгж буюу утгуудыг концепт гэж тодорхойлсон нь буй. Хэл шинжлэлд энэ нэр томъёоны тухай нэгдсэн ойлголт байхгүй байна. Түүний хэлбэр, бүтэц, төрлүүдийн талаар маргаантай, шийдвэрлээгүй асуудал өнөөг хүртэл цөөнгүй байна. Ингээд орос, монгол хэлний талархах үйлийн фрейм, слотын бүтцийг авч үзье.

Слот № 1. Мэдээлэл дамжуулах – талархах

Энэ төрлийн талархах үйлийн пресуппозиц нь мэдээлэл дамжуулах үйл болдог. Гэхдээ талархал илэрхийлэх үйл явц нь ихэвчлэн ёс төдий шинжтэй байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, мэдээллийг хүлээн авсныг л илтгэж буй хэрэг юм. Цаг хугацааны хувьд энэхүү үйлдэл нь “харьцангуй одоо цаг”-т болох бөгөөд сонсогч болон яригчийн яриа болж буй орчинд шууд явагдана.

“- На горе пикет, ваше сиятельство, все там же, где был с вечера, - доложил Ростов. - Хорошо, хорошо, - сказал Багратион, благодарю вас, господин офицер (Толстой, 1984).”

- Таны хорих ялнаас дөрвөн жил хэлтрүүлэх Бага хурлын тогтоол гарсан гээд уншив. - За тийм байж. Баярлалаа. Ер нь хийсэн хэрэг байхгүй. Намайг цагаатгахгүй юм бол хэдэн жил суугаад гарсан ч яахав дээ гэж Дандигай гоморхуу янзтай хэлэв.

Слот №2. Санал тавих – талархах

Санал тавих үйл нь дам мэдээлэл дамжуулах үйл бөгөөд пропозицын агуулга нь “харьцангуй одоо цаг”-тай дүйцнэ. Айлд зочлох үед юм уу ажил хэргийн шугамаар санал тавих үед элбэг тохиолдох бөгөөд бие биенээ муухан таньдаг хүмүүсийн хооронд юм уу эсвэл албархаг нөхцөл байдалд яриа өрнөдөг.

“- Я тебя вызвал, чтоб оставить при себе. - Благодарю, вашу светлость, - отвечал князь Андрей, - но я боюсь, что не гожусь больше для штабов, - сказал он с улыбкой, которую Кутузов заметил (Толстой, 1984).”

Жигмидийг докторын зэрэгт хүрээд ирэхээр түүнийг эрүүлийг хамгаалах яамны сайд болгох гэж Засгийн газар дуудах нь тэр. - Үгүй би сайд болохгүй. - Яагаад? - Би чадахгүй. - Доктор хүн, тэр дундаа хамаг зовлонгийг нь мэддэг хүн болохгүй бол хэн болох билээ? - Бид сайд болж албан конторт сууснаас хүн эмчилж явбал сайд болсноосоо ч илүү юм бүтээх болно. - За тэгвэл та явж байдаа. - Баярлалаа! Би эмч хүн. Эмчилгээ тэр дундаа одоо үед бүр ч чухал болж байгаа эмийн бус эмчилгээг дэлгэрүүлэхэд хүчин зүтгэхээ илэрхийлье.

Слот №3. Тус болох – талархах

Талархах үйлийн хамгийн түгээмэл тохиолддог хэлбэр бөгөөд үгэн ба үгэн бус хэрэгслүүдийг дангаар нь болон хослуулан хэрэглэх зэрэг олон янзын хүч нэмэгдүүлэх хэрэгслүүдийг ашигладаг онцлогтой. Сонсогчийн хийсэн санамсаргүй ч байж болох сайн үйлийн үнэ цэнээс үүдэн яригч хэрэгслээ сонгодог. Пропозицын агуулга нь нэлээд ойр өнгөрсөн цагаар хэмжигдэнэ.

“- Вы сделали моему папе редчайшую операцию. Еще раз примите нашу огромную благодарность... Он чувствует себя превосходно; и не знает, как вас благодарить. Вот эта

сумка вам. Он хотел приехать сам, да не мог вырваться с работы. Спасибо, Валерий Юрьевич! (Розенгантен, 1974)”

“Үдээс хойш генерал хошууны ноён туслагч хоёрыг гэртээ урив. - Та бүхэн намайг хүндэтгэн хүлээж авсанд туйлгүй баярлалаа. Энэ бол монголын ноёд, угсаатан нар баатар цагаан хаан, их орос улсыг талархан үздэгийн гэрч билээ ... (Лодойдамба, 1971).”

Мөн түүнчлэн энэ бүлгийн талархах үйлийн пропозицын агуулга ирээдүй цагтай холбоотой байх тохиолдол байдаг. Энэ нь яригч сонсогчоос тус болохыг гуйж талархал илэрхийлэх үед илэрдэг. Гэхдээ сонсогч түүний гуйлтыг биелүүлэх эсэх нь тодорхойгүй байна.

“- ... Вы не можете себе представить ту жажду его видеть, которую я испытываю, и потому не можете представить ту благодарность, которую во мне возбудит ваша помощь (Толстой Л. , Анна Каренина, 2008).”

“- ... Манайд сайхан айраг ирсэн. Очиж зоогловол би хэмжээлигүй баярлах байна (Лодойдамба, 1971).”

Гуйлт асуух өгүүлбэрээр хэлбэржих нь олонтоо бөгөөд яригч санасандаа хүрэхийн тулд эелдгийн айн зарчмыг баримтлах шаардлагатай байдаг.

“- О! Да, да, - отвечал, улыбаясь Альберт, - но извините меня, я не знаю, с кем имею честь говорить; может быть, вы граф или князь: не можете ли вы мне ссудить немного денег? Я ничего не имею... я бедный человек. Я не могу отдать вам. - Делесов покраснел, ему неловко стало, и он торопливо передал музыканту собранные деньги. - Очень благодарю вас, - сказал Альберт, схватив деньги, - теперь давайте музицировать; я, сколько хотите, буду играть вам (Толстой, Альберт, 1979).”

“- Тантай танилцсандаа би их баяртай байна. Маргааш орой ажил тарсны дараа манайд ирж цай уухгүй юу? гээд Урангоо инээмсэглээд гараа өгөхөд нь залуу ажилд хөрсжөөгүй зөөлөн гараараа чангахан атгахад түүний сэтгэл ихэд догдлон байгааг хүүхэн зөнгөөрөө гадарлажээ. - Баярлалаа танд. Заавал ирнэ ээ. Тавтай нойрсоорой гээд Билгүүн буцлаа (Бямба, Үнэний хорвоо, 1983).”

Слот №4. Санаа тавих – талархах

Мэндчилэх, баяр хүргэх, сайн сайхныг хүсэх зэрэг яригч сонсогчид анхаарал халамж тавьж байгааг илтгэдэг эелдэг үг хэллэгүүдэд хариу өгөх үйлдэл юм.

“- Я вас не поздравил, - сказал он, указывая на его новополученную ленту. - Благодарю вас, - ответил Александр Александрович (Толстой Л. , Анна Каренина, 2008).”

- За баяр хүргэе! Хүү минь та чинь мөн их зүтгэл хөдөлмөр хийж дээ. - Баярлалаа ах минь.

Мөн монгол хэлэнд “хүний үйлдэн бүтээж буй хөдөлмөрийг ерөөж мэндчилэх ёс их өргөн уламжлагджээ. Жишээлбэл, унгас ноос савж буй хүмүүстэй мэндлэхдээ: - Саваа чинь шандас

Савсан ноос чинь мяндас болох болтугай! гэж ерөөн мэндлэхэд: - *Тэр билэг бат сайхан орших болтугай!* гэж ерөөлийг хүлээн авснаа илэрхийлэн хариу талархдаг байна (Нямбуу & Арьяасүрэн, 1990).”

Слот №5. Ерөөл болон бэлэг дэмбэрлийн үг хэлэх – талархах

Монгол ардын аман зохиолын нэгэн төрөл болох ирээдүйд сайн сайхан зүйл болохыг бэлгэшээсэн утга агуулга бүхий бэлэг дэмбэрлийн үг, ерөөлийн хариуд хэлж буй энэ хэлбэрийн талархах үйл монгол хэлэнд илүү түгээмэл ажиглагдаж байна. “Ерөөлийг тусгай зан үйл, баяр ёслолын үед хэлдэг бол, бэлэг дэмбэрлийн үгийг өөрийн болон бусдын ажил хөдөлмөр, нөхцөл байдалд тохируулан өдөр тутамдаа хэлж болдог. Ерөөл хэлж гүйцмэгц сонсогчид нийтээр түүний утгыг бататгасан утга бүхий хос мөр хэлдэг бол бэлэг дэмбэрлийн үгийн хариуд хэлдэг тусгай үг бий (Сампилдэндэв, 1999).” Тухайлбал, *Ориутгай, Ерөөл өлзий болтугай, Ам өлзий болтугай, Ерөөл болтугай* гэх мэтээр наргиантайгаар талархал илэрхийлдэг байна. Орос хэлэнд *С богом, Расту большою, Будь молодцом* гэх зэрэг цөөн үг хэллэг тааралддаг. Иймэрхүү талархах үйлийн пропозицын агуулга нь харьцангуй одоо цагт хамаарах нэг удаагийн үйлдлийг заана.

“Проехав так минут десять, Петруха обернулся и что-то прокричал. Ни Василий Андреич, ни Никита не слышали от ветра, но догадались, что они проехали к повороту. - Ну, с богом! - Спасибо, Петруха! (Толстой, Хозяин и работник, 2007)”

“- Монгол улсыг төлөөлж яваа эрхэм төлөөлөгч таныг сайн явж хүрэхийн ерөөл дэвшүүлье. - Их баярлалаа танд (Бямба, Үнэний хорвоо, 1983). ”

Слот №6. Худалдан авалт хийх – талархах

“Худалдагч – худалдан авагч” гэсэн нөхцөлд худалдагч худалдан авагчид орлого оруулсанд нь талархаж буй явдал юм. Зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнө эсрэгээрээ худалдан авагч худалдагчид талархал илэрхийлэх явдал хэвшиж тогтсон байсныг дурдах хэрэгтэй. Илэрхийлэх хэлбэр нь дан ганц “Баярлалаа” гэдэг үгээр хязгаарлагдана. Иймэрхүү талархах үйл үйлчилгээний бүхий л салбарт ажиглагдах “харьцангуй одоо цаг”-т болсон нэг удаагийн үйлдлийг заадаг.

Судалгааны үр дүн

Оросын хэл шинжлэлч А.Г.Бердникова талархах үйлийн фреймийн бүтцийг дараах бүдүүвчээр илэрхийлж болно (Бердникова, 2000) гэж үзжээ. Үүнд:

Субъект (хэн?) + предикат (талархаж байна) + способ (яаж?) + объект (хэнд?) + каузатор (юунд?).

Цаашлаад тэрээр талархах утгатай өгүүлэмжийн бүтцийг тодорхойлох дараах томъёог санал болгожээ. Үүнд:

$$S + Pr + O \pm K,$$

Энд:

S – талархал илэрхийлж буй субъект,

Pr – талархах утгатай предикат,

O – объект буюу талархлыг хүлээн авагч,

K – каузатор буюу талархах болсон шалтгаан.

Бид энэ дотроос чухамхүү каузатор гэсэн параметрт үндэслэн орос, монгол хэлний талархах үйлийг зургаан слотод хуваан авч үзэж болох юм гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Улмаар орос, монгол сонгодог уран зохиолоос түүвэрлэн авсан талархах утга бүхий 1000 орчим өгүүлэмжид тэдгээрийн эзлэх хувийг авч үзэхэд мэдээлэл дамжуулсны хариуд талархах үйл орос хэлэнд 14%, монгол хэлэнд 15%, санал тавьсны хариуд талархах үйл орос хэлэнд 10%, монгол хэлэнд 8%, тус болсны хариуд талархах үйл орос хэлэнд 37%, монгол хэлэнд 40%, санаа тавьсны хариуд талархах үйл орос хэлэнд 29%, монгол хэлэнд 19%, ерөөл болон бэлэг дэмбэрлийн үг хэлсний хариуд талархах үйл орос хэлэнд 7%, монгол хэлэнд 14%, худалдан авалт хийсний хариуд талархах үйл орос хэлэнд 3%, монгол хэлэнд 4%-ийг тус тус эзэлж байна гэсэн дүн гарлаа.

Дүгнэлт

Тус болсны хариуд талархах үйл орос, монгол аль ч хэлэнд хамгийн түгээмэл хэрэглэгддэг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Мөн түүнчлэн ерөөл болон бэлэг дэмбэрлийн үг хэлсний хариуд талархах үйл орос хэлэнд 7%, монгол хэлэнд 14% буюу монгол хэлэнд хоёр дахин их тохиолдож байгаа нь ардын аман зохиолын нэгэн төрөл болох ерөөл болон бэлэг дэмбэрлийн үгийг монголчууд өдөр тутам ахуй амьдралдаа хэрэглэж заншсаныг харуулж байна. Ийнхүү хоёр хэлний талархах үйлийг дээрх хэлээр бичигдсэн сонгодог уран зохиолоос түүвэрлэн авсан талархах утга бүхий 1000 орчим жишээн дээр зэрэгцүүлэн судалж үзээд адил төстэй зүйл нэлээд байгаа боловч тухайн орнуудын нийгэм, соёлын онцлогтой холбоотой ялгаатай зүйл ч бас байгааг тогтоолоо. Бидний ажлын үр дүн болон дүгнэлтийг хэлэх үйлийн онол болон хэлэх үйлийн фреймийн анализыг сонирхон судалж буй хэл шинжлэлчид судалгааныхаа ажилд ашиглах боломжтой юм.

Ашигласан материалын жагсаалт

Айвазова, В. (2011). *Когнитивное исследование фрейма-сценария «благодарность» в различных видах англоязычного и немецкоязычного дискурса*. Сургут.

Бердникова, А. (2000). *Концепт «Благодарность» в русской языковой картине мира*. Новосибирск: Изд-во НГПУ.

Бямба, Ж. (1971). *Энэрэлгүй хорвоо*. Улаанбаатар.

- Бямба, Ж. (1983). *Үнэний хорвоо*. Улаанбаатар.
- Желтухина, М. (2003). *Тропологическая суггестивность массмедиаального дискурса*. Волгоград: Изд-во ВФ МУПК.
- Лодойдамба, Ч. (1971). *Тунгалаг Тамир*. Улаанбаатар.
- Нямбуу, Х., & Арьяасүрэн, Ч. (1990). *Монгол ёс заншлын бага тайлбар толь*. Улаанбаатар : Улсын хэвлэлийн газар.
- Остин, Д. Л. (1986). Слово как действие. In Б. Ю. Городецкий (Ed.), *Новое в зарубежной лингвистике* (А. А. Медникова, Trans., Vol. 17, pp. 22-129). Москва, Россия: Прогресс.
- Розенгантен, М. Ю. (1974). *Страницы из жизни хирурга*. Москва.
- Рудаков, А. (2002). *Когнитология и когнитивная лингвистика*. Воронеж.
- Рыбаков, А. Н. (1980). *Приключения Кроша*. Москва: Детская литература.
- Сампилдэндэв, Х. (1999). *Монгол хуримын яруу найргийн төрөл зүйл*. Улаанбаатар.
- Толстой, Л. (1979). *Альберт*. Москва.
- Толстой, Л. (1984). *Война и мир*. Москва.
- Толстой, Л. (2007). *Хозяин и работник*. Москва: Эксмо.
- Толстой, Л. (2008). *Анна Каренина*. Москва.
- Төмөрхуяг, Б. (2011). *Улс төрийн дискурс дэх метафорыг когнитив хэл шинжлэлийн үүднээс судалсан нь: монгол, орос, англи хэлний жишээн дээр*. Улаанбаатар.